



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны 0᠖ сарын ᠒᠐ өдөр Дугаар А/18᠑

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 45
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 35,179,750.00 (гучин таван сая нэг зуун далан есөн мянга долоон зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 166 дугаар сургуулийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургууль (Б.Наранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиглахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 166 дугаар сургууль (А.Энхтуяа)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА

В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 9 дугаар сарын 10-ны
өдрийн АИХ-дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургууль

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2025 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Сурагч ширээ 1200*400-420*760	2022	ш	15	14,850.00	222,750.00	55,687.50	167,062.50	НЭБ-н 45 дугаар сургууль	НЭБ-н 166 дугаар сургууль
2	Ахлах ангийн ширээ	2022	ш	24	234,000	5,616,000.00	5,616,000.00	-		
3	Ахлах ангийн сандал	2022	ш	31	162,000	5,022,000.00	5,022,000.00	-		
4	Дунд ангийн ширээ	2022	ш	76	220,000	16,720,000.00	16,720,000.00	-		
5	Дунд ангийн сандал	2022	ш	51	149,000	7,599,000.00	7,599,000.00	-		
	Дүн			197		35,179,750.00	10,693,687.50	167,062.50		